



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

VISION
ZERO
FUND

SCORE

► **Жижиг, дунд аж ахуйн нэгжид
хөдөлмөрийн аюулгүй байдал,
эрүүл мэндийг сайжруулах нь**

СУРГАГЧ БАГШИД ЗОРИУЛСАН УДИРДАМЖ



- ▶ **Жижиг, дунд аж ахуйн нэгжид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг сайжруулах нь**

СУРГАГЧ БАГШИД ЗОРИУЛСАН УДИРДАМЖ



Энэхүү сургалтын багц нь Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын Хөдөлмөрийн удирдлага, хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хэлтэс ХУХ/ХАБЭМХ, ОУХБ-ын Өрсөлдөх чадвартай, хариуцлагатай аж ахуйн нэгжийг дэмжих хөтөлбөр (SCORE) болон Vision Zero буюу “Ослыг тэглэх алсын хараа” сангийн хамтын бүтээл юм. Сургалтын багцыг ХУХ/ХАБЭМХ-ийн Хөдөлмөрийн хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн Эндрю Кристиан, SCORE хөтөлбөрийн техникийн ажилтан Пранати Мехта, Vision Zero сангийн техникийн ажилтан Мария Е. Мунаретто нар тус сангийн Этиоп дахь техникийн ажилтан Эванс Лванга, ОУХБ-ын “Better Work” хөтөлбөрийн техникийн ажилтан Кесава Мурали Канапати нарын дэмжлэгтэйгээр боловсрууллаа.

Хөдөлмөрийн удирдлага, хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хэлтэс (ХУХ/ХАБЭМХ)

Хөдөлмөрийн удирдлага, хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан тус хэлтэс нь төр, ажил олгогчид болон ажиллагчдад тулгамдаж буй нэн тэргүүний асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх цогц стратеги боловсруулахыг зорьж ажилладаг. “Хөдөлмөрийн аюулгүй байдал + Эрүүл мэнд” тэргүүлэх хөтөлбөрийнхөө хүрээнд ОУХБ-ын түншлэгч талуудад мэдлэг бий болгох, үндэсний чадавхыг бэхжүүлэх, эрүүл, аюулгүй ажлын байрыг дэмжих тогтолцоо бүрдүүлэх, эрүүл, аюулгүй ажлын байрны эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэх гэсэн стратегийн дөрвөн чиглэлээр дэмжлэг үзүүлдэг.

Өрсөлдөх чадвартай, хариуцлагатай аж ахуйн нэгжийг дэмжих хөтөлбөр (SCORE)

Энэ нь ОУХБ-аас жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн бүтээмж, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах зорилгоор хэрэгжүүлж буй олон улсын хөтөлбөр юм. Хөтөлбөрийн гол зорилго нь танхимын практик сургалтыг үйлдвэр дээр зөвлөн туслах үйлчилгээтэй хослуулсан аргачлал бүхий SCORE сургалтыг үр дүнтэй зохион байгуулахад оршдог. Дэлгэрэнгүй мэдээлэл: ilo.org/score

Vision Zero буюу “Ослыг тэглэх алсын хараа” сан

Vision Zero сан нь засгийн газрууд, ажил олгогчийн болон ажилтны төлөөллийн байгууллагууд, компаниуд болон бусад оролцогч талуудыг нэгтгэн, олон улсын нийлүүлэлтийн сүлжээнд ажил, хөдөлмөртэй холбоотой ноцтой болон амь насанд хүрэх осол, гэмтэл, өвчлөлийг тэг болгох алсын харааг хамтран хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. Ингэхдээ олон улсын, үндэсний болон ажлын байрны түвшинд хүрч ажиллан эрүүл, аюулгүй ажиллагааг дэмжсэн орчин, нөхцөлийг бүрдүүлэх, үндэсний хууль тогтоомж, бодлогыг боловсронгуй болгох, ханган нийлүүлэлтийн тодорхой сүлжээнд ажиллаж буй эмэгтэй, эрэгтэй хүмүүсийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, нөхөн төлбөр олгуулах илүү үр дүнтэй механизм хэрэгжүүлэхийг зорьж байна. Дэлгэрэнгүй мэдээлэл: ilo.org/vzf



Attribution 4.0 International (CC BY 4.0)

Энэхүү сургалтын багцыг Creative Commons Attribution 4.0 Олон улсын тусгай зөвшөөрлийн хүрээнд олон нийтэд нээлттэй байршуулсан болно (<https://creativecommons.org/licenses/by/4.0/>). Тусгай зөвшөөрлийн хүрээнд уг гарын авлагыг дахин ашиглах, нийтэд түгээх, нэмж өөрчлөх, хөгжүүлэх боломжтой. Ингэхдээ ОУХБ-ыг хэвлэлийн анхны хувилбарыг эзэмшигч гэдгийг тодорхой тусгаж өгнө. Дахин ашиглах, нийтэд түгээх, нэмж өөрчлөх, хөгжүүлэх тохиолдолд ОУХБ-ын логог ашиглахыг хориглоно.

Зохиогч – Сургалтын багцыг дараах байдлаар эшлэнэ: Жижиг, дунд аж ахуйн нэгжид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг сайжруулах нь- Сургагч багшид зориулсан удирдамж, Женев: Олон Улсын Хөдөлмөрийн Товчоо, 2025. © ILO.

Орчуулга – Сургалтын багцыг орчуулсан тохиолдолд дараах тайлбарыг заавал оруулсан байх ёстой: Энэ нь ОУХБ-ын зохиогчийн эрх бүхий бүтээлийн орчуулга юм. ОУХБ нь энэхүү орчуулгыг бэлтгэж, хянаж, батлаагүй бөгөөд ОУХБ-ын албан ёсны орчуулга биш юм. Тус хувилбарын агуулга, үнэн зөв байдлыг ОУХБ хариуцахгүй бөгөөд орчуулан гаргасан зохиогчид бүрэн хариуцна.

Өөрчлөлт – Сургалтын багцын агуулгыг өөрчлөн гаргасан тохиолдолд дараах тайлбарыг заавал оруулна: Энэхүү бүтээл нь ОУХБ-аас гаргасан зохиогчийн эрх бүхий бүтээлийг өөрчлөн боловсруулсан хувилбар юм. ОУХБ нь энэхүү хувилбарыг бэлтгэж, хянаж, батлаагүй бөгөөд ОУХБ-аас албан ёсоор өөрчлөн боловсруулсан хувилбар биш болно. Тус хувилбарын агуулга, үнэн зөв байдлыг ОУХБ хариуцахгүй бөгөөд өөрчлөн гаргасан зохиогчид бүрэн хариуцна.

Гуравдагч талын материал – Энэхүү тусгай зөвшөөрөл нь гарын авлагад тусгагдсан ОУХБ-ын бус зохиогчийн эрхтэй хэсэгт хамаарахгүй. Хэрэв тус хэвлэлд эшлэгдсэн гуравдагч талын зохиогчийн эрх бүхий материалыг ашиглах бол эзэмших эрх болон аливаа зөрчлийн асуудлаар зөвхөн тухайн зохиогчид хандана.

Тусгай зөвшөөрлийн дагуу үүссэн, эвийн журмаар шийдвэрлэх боломжгүй аливаа маргааныг НҮБ-ын Олон Улсын Худалдааны Эрхийн Комиссын Арбитрын журмын дагуу арбитрын шүүхэд шилжүүлнэ. Маргааныг арбитрын шүүх эцэслэн шийдэх бөгөөд талууд шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.

Зохиогчийн эрх болон тусгай зөвшөөрөлтэй холбоотой аливаа асуудлаар ОУХБ-ын Хэвлэлийн албанд (Зохиогчийн эрх ба тусгай зөвшөөрөл) rights@ilo.org хаягаар хандана уу. ОУХБ-ын хэвлэл болон дижитал бүтээгдэхүүний талаарх мэдээллийг дараах холбоосоор авах боломжтой: www.ilo.org/publns.

ISBN: 9789220428054 (хэвлэмэл); 9789220428061 (веб PDF)

Энэхүү сургалтын багцын англи хэл дээрх хувилбар: Improving occupational safety and health in small and medium-sized enterprises: Trainer's guide, ISBN 9789220339619 (хэвлэмэл), 9789220339626 (веб PDF)

Франц хэл дээрх хувилбар: Améliorer la sécurité et la santé au travail dans les petites et moyennes entreprises: guide du formateur, ISBN 9789220342176 (хэвлэмэл), 9789220342046 (веб PDF)

Испани хэл дээрх хувилбар: Mejora de la seguridad y salud en el trabajo en las pequeñas y medianas empresas: manual del formador, ISBN 9789220342183 (хэвлэмэл), 9789220342039 (веб PDF)

Украин хэл дээрх хувилбар: ISBN: 9789220353103 (хэвлэмэл), 9789220353110 (веб PDF)

ОУХБ-ын мэдээллийн сан, хэвлэлд ашиглагдсан материал нь НҮБ-ын зарчимд нийцсэн бөгөөд ОУХБ-ын аливаа улс орон, нутаг дэвсгэрийн эрх зүйн байдал, эрх мэдэл, эсвэл тэдгээрийн хил хязгаарын талаарх илэрхийлсэн байр суурь, илэрхийлэл биш болно.

Хэвлэлд тусгагдсан үзэл, санаа бодол нь зөвхөн зохиогчийнх бөгөөд ОУХБ-ын үзэл бодол, байр суурь, бодлого биш юм.

Байгууллага, бүтээгдэхүүн, үйл явцыг эш татсан нь ОУХБ тэдгээрийг албан ёсоор хүлээн зөвшөөрснийг илтгэхгүй. Мөн бусад байгууллага, бүтээгдэхүүн, үйл явцыг дурдаагүй нь тэдгээрийг хүлээн зөвшөөрөөгүйн шинж биш болно.

1. Танилцуулга	9
2. ОУХБ-ын “Жижиг, дунд аж ахуйн нэгжид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг сайжруулах нь” сэдэвт модуль	10
Сургагч багшийн гүйцэтгэх үүрэг	10
Зорилго	11
3. Сургалтын хөтөлбөр	12
4. Хичээлийн төлөвлөгөө	13
Эхний өдөр	14
Хичээл 1. Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн ХАБЭМ-ийн нөхцөл байдлын талаарх танилцуулга	14
Хичээл 2. ХАБЭМ-ийн тодорхойлолт ба үндсэн ойлголтууд	15
Хичээл 3. Эрсдэлийн үнэлгээний үйл явц	17
Хоёр дахь өдөр	19
Хичээл 4. Эрсдэлийг хянах арга хэмжээний шатлал	19
Хичээл 5. Эрсдэлийн үнэлгээний үйл явц (үргэлжлэл)	20
Хичээл 6. ХАБЭМ-ийн удирдлагын тогтолцоо	21
Хичээл 7. Арга хэмжээ авах	22
5. Тараах материал	24
Т/М 1: Сургалтын хөтөлбөр	24
Т/М 2: Өдрийн үнэлгээний хуудас	25
Т/М 3: Эрсдэлийн үнэлгээний маягт	25
Т/М 4: Ажлын байранд болсон тохиолдлыг мэдээлэх маягтын загвар	28
Т/М 5: Эрсдэлтэй хүмүүсийг тодорхойлж, ажлын байран дахь эрсдэлийн түвшинг үнэлэх	30

Т/М 6а: Сайжруулах санал	31
Т/М 6б: Аж ахуйн нэгжийг сайжруулах төлөвлөгөө	32
Т/М 7: Сургалтын үнэлгээ	33
6. Сургагч багшид зориулсан тэмдэглэл	35
СБ/Т 1: Сургагч багшийн хийх ажил	35
СБ/Т 2: Дасгал: Жижиг бизнес, том сорилт	35
СБ/Т 3: Үйлдвэрийн дасгал 1. Ажлын байран дахь аюулыг илрүүлэх	36
СБ/Т 4: Үйлдвэрийн дасгал 2: Ажлын байран дахь эрсдэлийг үнэлэх	36
СБ/Т 5. Үйлдвэрийн дасгал 3: Үйлдвэрийн дасгал 2-т үнэлсэн эрсдэлийг хяналтын шатлалын дагуу хянах арга хэмжээг санал болгох	38
СБ/Т 6. Дасгал: Арга хэмжээ авах	38
СБ/Т 7. Дасгал (сонголтоор): ХАБЭМ-ийн хамтарсан хороо	40
Хэрэгцээт холбоос	41

Энэхүү баримт бичгийг Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр боловсруулав. Энд тусгагдсан үзэл бодол, байр суурь нь Европын Холбооны албан ёсны байр суурийг аливаа байдлаар илэрхийлэхгүй болно.

► 1. ТАНИЛЦУУЛГА

Сургагч багшид зориулсан энэхүү удирдамжид ОУХБ-ын “Жижиг, дунд аж ахуйн нэгжид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг сайжруулах нь” сэдэвт сургалтын модулийг танхимийн нөхцөлд, мэргэжлийн түвшинд заахад шаардагдах мэдээлэл, заавар, зөвлөмжийг тусгалаа.

ОУХБ-ын Өрсөлдөх чадвартай, хариуцлагатай аж ахуйн нэгжийг дэмжих хөтөлбөр (SCORE), Хөдөлмөрийн удирдлага, хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хэлтэс (ХУХ/ХАБЭМХ) болон Vision Zero сан хамтран SCORE хөтөлбөрийн “ХАБЭМ – Бүтээмж нэмэгдүүлэх суурь” сэдэвт сургалтын модульд үндэслэж энэхүү сургалтын модулийг боловсруулсан юм.

► ХЭНД ЗОРИУЛАГДСАН БЭ?

Энэхүү удирдамж нь ХАБЭМ-ийн шинэ болон туршлагатай сургагч багш нарт зориулагдсан болно. Сургагч багш оролцогчдыг сургалтын үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, хичээлийн үндсэн материал, (сурсан зүйлээ ажлын байрандаа хэрэгжүүлэхэд нь туслах зорилгоор боловсруулсан) тусгай хэрэглэгдэхүүнийг үр дүнтэй ашиглах боломж бүрдүүлэхэд нь энэхүү удирдамж тусална.

► ХЭРХЭН ХЭРЭГЛЭХ ВЭ?

Сургалтад бэлтгэх, зохион байгуулахад энэхүү удирдамжид багтсан хичээлийн төлөвлөгөө, алхам алхмаар хэрэгжүүлэх заавар, тараах материал зэргийг ашиглаж болно. ОУХБ-ын стандартад нийцсэн, өндөр чанартай сургалт зохион байгуулахын тулд энэхүү удирдамжийг холбогдох бусад материалтай хамт хэрэглэхийг зөвлөж байна. Үүнд:

- ОУХБ-ын “Жижиг, дунд аж ахуйн нэгжид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг сайжруулах нь” сэдэвт модулийн суралцагчийн гарын авлага
- ОУХБ-ын “Жижиг, дунд аж ахуйн нэгжид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг сайжруулах нь” сэдэвт модулийн хичээлийн танилцуулга (PPT илтгэл)

▶ 2. ОУХБ-ЫН “ЖИЖИГ, ДУНД АЖ АХУЙН НЭГЖИД ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙГ САЙЖРУУЛАХ НЬ” СЭДЭВТ МОДУЛЬ

ОУХБ-ын “Жижиг, дунд аж ахуйн нэгжид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг сайжруулах нь” сэдэвт модуль нь ХАБЭМ-ийн сургалтын хөтөлбөр юм. Энэ нь ажлын байранд буй эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийг илрүүлж, шийдвэрлэх арга замыг санал болгоход тань туслах арга хэрэгслийг танилцуулах зорилготой. Модуль нь дараах хандлагад суурилсан болно. Үүнд:

- ▶ Асуудлыг хамтран шийдвэрлэх;
- ▶ Ажлын байран дахь харилцаа, хамтын ажиллагаа;
- ▶ Сайжруулалтад системтэй хандах;
- ▶ Тасралтгүй сайжруулалтыг хэмжих, үнэлэх.

▶ СУРГАГЧ БАГШИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Энэхүү модулийн сургагч багшийн хувьд та дээр дурдсан хандлагад онцгой анхаарал хандуулах үүрэгтэй. Иймд баг бүрдүүлэлт болон ажлын байран дахь харилцаанд анхаарах нь аж ахуйн нэгжийн сайн туршлага, ашигт ажиллагаа, өрсөлдөх чадварыг хэрхэн нэмэгдүүлж болох талаар оролцогчдод тодорхой жишээ танилцуулах шаардлагатай. Сургалтын дараа аж ахуйн нэгж бүрийн бөглөсөн өөрийн үнэлгээний хуудастай танилцаж, тус бүрийнх нь сайжруулалтын багтай хамтран сургалтын дараа 4–6 долоо хоногийн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах хэрэгтэй.

Ажилтнуудын идэвхтэй оролцоо нь энэхүү хөтөлбөр болоод аливаа зүйлийг сайжруулах оролдлого амжилттай хэрэгжих зайлшгүй урьдач нөхцөл билээ. Иймд та сургалтын бүх үйл ажиллагаа, илтгэлдээ энэ санааг онцлон тэмдэглэж, бататган ойлгуулах шаардлагатай.

Сургалтын модуль нь долоон хичээлээс бүрдэнэ. Үүнд сургалтын ерөнхий танилцуулга, үндсэн сэдвүүд, “арга хэмжээ авах” гэсэн төгсгөлийн хичээл багтана. Сургалтыг өдөрт 6 цагаар, хоёр өдөр зохион байгуулах нь тохиромжтой. Гэхдээ оролцогчдын цагийн боломж, бусад нөхцөл байдлыг харгалзан уян хатан хандах нь зүйтэй. Энэ нь оролцогчдод өөрсдийн мэдлэг, туршлагаа хуваалцах боломж олгосон оролцооны аргаар явагдах, практик сургалт гэдгийг санаарай.

Сургагч багшийн хийх зүйлийн жагсаалтыг Сургагч багшид зориулсан тэмдэглэл СБ/Т 1-д оруулав. Энэхүү жагсаалт сургалтад бэлтгэхэд тань тусална.

► ЗОРИЛГО

Энэ модулийн төгсгөлд оролцогч дараах чадварыг эзэмшсэн байна:

- Аюулгүй байдал, эрүүл мэндийн аюул, эрсдэлийг илрүүлэх, үнэлэх
- Эрсдэлийг арилгах, бууруулахад чиглэсэн үндсэн арга, дүрэм, журмыг хэрэгжүүлэх:
 - ХАБЭМ-ийн удирдлагын тогтолцоо, бодлого
 - ХАБЭМ-ийн асуудлаарх хамтарсан хороо
 - Аюулгүй ажиллагааны холбогдох стандартууд
- Эрүүл/аюулгүй ажлын байрны өдөр тутмын үйл ажиллагааг удирдах.

Эдгээр зорилгод хүрэхийн тулд сургагч багш нь бүлгийн хэлэлцүүлэг, симуляци, санал уралдуулах, туршлага солилцох, дасгал ажиллах, тохиолдол шинжлэх, дүрд тоглох зэрэг идэвхтэй оролцооны аргыг ашиглан суралцах орчныг бүрдүүлэх нь зүйтэй.

Орчин үед насанд хүрэгчид хамтран ажиллах, туршлагаа солилцох байдлаар суралцдаг болоод байна. Иймд сургалтаар оролцогчдод нийтлэг зарчмуудаа танилцуулаад өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, санаагаа солилцох таатай нөхцөл бүрдүүлэх нь чухал. Хүн бүрд тухтай, нөхөрсөг уур амьсгал бүрдүүлж, дуугай/бүрэг оролцогчдыг хэлэлцүүлэг, бусад үйл ажиллагаанд татан оролцуулахыг эрмэлзэх хэрэгтэй. Сургалт тухайн сэдэвтээ төвлөрч, цагийн хуваарийнхаа дагуу явагдахад сургагч багш анхаарна. Ингэхдээ жендэрийн асуудалд хүндэтгэлтэй хандаж, нийт оролцогчдын тэгш оролцоог хангахыг эрмэлзэнэ. Ийм идэвх, оролцоог дэмжсэн арга барилыг хэрэгжүүлэхийн тулд хичээлийг уламжлалт лекц хэлбэрээр бус, харин “хамтдаа суралцах” үйл явц болгон зохион байгуулах шаардлагатай. Үүнд сургагч багш асуулт тавих, оюун бодлоо уралдуулж, шүүмжит сэтгэлгээгээр хандахыг дэмжих, оролцогчдын оролцоог эерэгээр үнэлж, хүн бүр адил тэгш, үнэ цэнтэй гэсэн мэдрэмжийг төрүүлэх зэрэг багтана.

Power Point дээр бэлдсэн (долоон хичээл болон тус бүрийн дасгалыг багтаасан) илтгэлийг танилцуулахад тус дөхөм болох нэмэлт тэмдэглэлийг слайд бүрийн дор оруулсан болно.

3. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Сургалтын агуулгыг хоёр өдөрт хувааж, эхний өдөр 3 хичээл, хоёр дахь өдөр 4 хичээл орохоор зохицуулав. Маш тодорхой зорилт бүхий шахсан агуулгатай сургалтад энэ төлөвлөлт тохирно.

Хичээл бүрээр тавьсан зорилгодоо хүрэхэд нь оролцогчдод туслах дасгал ажил орууллаа. Ихэнх дасгал нь сургалтын хамгийн сүүлийн хичээлээр боловсруулах үйл ажиллагааны төлөвлөгөөний бэлтгэл байх болно.

Эхний өдөр	Сэдэв	Үйл ажиллагааны хэлбэр, оролцоо
90 мин	- Нээлтийн үг - Оролцогчдын танилцуулга - Сургалтын зорилго - Хөтөлбөрийн танилцуулга - Зочин илтгэл: Монгол улс дахь ХАБЭМ-ийн нөхцөл байдал, хууль, тогтоомж	Танилцуулга Сургагч багш, оролцогчид
	Хичээл 1: Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн ХАБЭМ-ийн нөхцөл байдал: тойм ба үндэслэл	Илтгэл, нэгдсэн хэлэлцүүлэг
30 мин	Завсарлага	
90 мин	Хичээл 2: ХАБЭМ-ийн тодорхойлолт ба үндсэн ойлголтууд	Илтгэл - Сургагч багш
30 мин	Дасгал: Аюулыг олж илрүүлэх Дасгал: Австралийн Нью Саут Уэльс мужийн ХАБЭМ-ийн агентлаг (SafeWork NSW)-ийн жишээ	Бүлгийн ажил, нэгдсэн хэлэлцүүлэг
60 мин	Үдийн завсарлага	
60 мин	Хичээл 3: Эрсдэлийн үнэлгээ	
	Алхам 1: Аюулыг илрүүлэх	Илтгэл - Сургагч багш
30 мин	Завсарлага	
30 мин	Үйлдвэрийн дасгал 1: Ажлын байрны аюулыг илрүүлэх	Бүлгийн ажил, нэгдсэн хэлэлцүүлэг
30 мин	Алхам 2: Хэн, хэрхэн хохирч болохыг тодорхойлох. Одоо байгаа эрсдэлийг үнэлэх	Илтгэл - Сургагч багш
	Алхам 3: Аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийг хянах арга хэмжээг тодорхойлж, сонгох	
30 мин	Үйлдвэрийн дасгал 2: Эрсдэлтэй хүмүүсийг тодорхойлж, ажлын байрны эрсдэлийн түвшинг үнэлэх	Бүлгийн ажил, нэгдсэн хэлэлцүүлэг

Хоёр дахь өдөр	Сэдэв	Үйл ажиллагааны хэлбэр, оролцоо
10 мин	Эхний өдрийн тойм ба хоёр дахь өдрийн танилцуулга	Танилцуулга Сургагч багш, оролцогчид
80 мин	Хичээл 4: Эрсдэлийг хянах арга хэмжээний шатлал	Илтгэл - Сургагч багш
30 мин	Завсарлага	
30 мин	Бэлэн хувцасны үйлдвэрийн дасгал	Нэгдсэн хэлэлцүүлэг
90 мин	Хичээл 5: Эрсдэлийн үнэлгээний үйл явц (үргэлжлэл) Үйлдвэрийн дасгал 3: Хяналтын арга хэмжээ санал болгох Нэмэлт дасгал: Өрмийн машин	Илтгэл ба дасгал
60 мин	Үдийн завсарлага	
60 мин	Хичээл 6: ХАБЭМ-ийн удирдлагын тогтолцоо	Сургагч багш, оролцогчид
30 мин	Завсарлага	
	Хичээл 7: Арга хэмжээ авах	Илтгэл - Сургагч багш
60 мин	Авах арга хэмжээг төлөвлөх дасгал	Илтгэл - Сургагч багш
30 мин	Сургалтын үнэлгээ ба санал зөвлөмж	Бүгд

4. ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хичээл бүрийг оролцогчид тухайн сэдвийн агуулгыг ойлгож, авсан мэдээллээ тунгааж бодох, дасгал ажиллах боломжтой байхаар төлөвлөсөн юм. Ингэснээр эдгээр үйл ажиллагаа нь хамгийн сүүлчийн хичээлээр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад тус дөхөм болно.

Бүх хичээлд дараах зүйлс ашиглагдана:

- ▶ Эргэдэг цаасан самбар
- ▶ Дижитал проектор
- ▶ Маркер үзэг
- ▶ PPT илтгэл
- ▶ Суралцагчийн гарын авлага

Энэхүү сургагч багшийн удирдамжид нэмэлтээр ашиглаж болох хэрэглэгдэхүүн, тараах материалыг оруулав. Хичээлийн төлөвлөгөөнд эдгээрийг хэзээ ашиглахыг заасан болно. PPT илтгэлд мөн эдгээр хэрэглэгдэхүүнийг хэзээ хэрэглэх талаар хэрэгцээтэй мэдээллийг орууллаа.

Тэмдэглэл: Бүлгээр ажиллах бүх дасгалд оролцогчид жижиг бүлэгт хуваагдан ажиллана (бүлэг бүр 5-6 хүнтэй байхын зэрэгцээ боломжтой бол нэг аж ахуйн нэгжийн хүмүүс байвал зохино). Бүх хичээлийн туршид эргэдэг цаасан самбар ашиглах боломж бүрдүүлнэ.

► ЭХНИЙ ӨДӨР

ХИЧЭЭЛ 1. ЖИЖИГ, ДУНД АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ХАБЭМ-ИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

Зорилго: Ажиллагчдын амьдралын чанарыг дээшлүүлэх, дэлхийн хэмжээнд эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжих, эдийн засгийн хөгжилд чухал нөлөөтэй аж ахуйн нэгжүүдэд хувь нэмэр оруулах талаас нь ХАБЭМ-ийн үүргийг тоймлон танилцуулах.

ХАБЭМ-ийн асуудал яагаад аж ахуйн нэгжийн анхаарлын төвд байх ёстойг тайлбарлах. Жижиг, дунд аж ахуйн нэгжүүд ХАБЭМ-ийн эрсдэл илүү их, нөөц боломж багатай байдаг тул ХАБЭМ онцгой ач холбогдолтойг тэмдэглэх.

Арга хэлбэр: Лекц

Материал: РРТ илтгэл (хичээл 1), СБ/Т 2. Тараах материал: Суралцагчийн гарын авлага, Т/М 1

Хамрах агуулга: Суралцагчийн гарын авлагын танилцуулга хэсэг, Бүлэг 1

Хугацаа: 1 цаг 30 мин

► Хичээлийн төлөвлөгөө

Хугацаа	Агуулга	Арга	Хэрэглэгдэхүүн/ Тараах материал
30 мин	Танилцуулга Оролцогчдын хүлээлт	Оролцогчидтой мэндчилэн өөрсдийгөө болон багийнхаа гишүүдийг танилцуулахыг урих. Аж ахуйн нэгж бүрээс нэг оролцогчийг өөрийн компаниа товч танилцуулж, сургалтаас хүсэн хүлээж буй зүйлээ хуваалцахыг хүсэх.	Суралцагчийн гарын авлагын танилцуулга хэсэг
30 мин	Тойм, сургалтын зорилго, хөтөлбөр	Лекц: -Сургалтын модулийг ерөнхийд нь тоймлон танилцуулах - Сургалтын зорилго, хөтөлбөрийг тайлбарлах - Оролцогчдын хүлээлтийг сургалтын агуулгатай холбох	РРТ илтгэл Сургалтын хөтөлбөр (Т/М 1)

Хугацаа	Агуулга	Арга	Хэрэглэгдэхүүн/ Тараах материал
30 мин	Хичээл 1: Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн ХАБЭМ-ийн нөхцөл байдлын талаарх танилцуулга	Лекц (оюуны довтолгоо аргачлалтай хослуулна): - Оролцогчдоос ХАБЭМ-ийн талаарх ойлголтыг нь асуух - Жижиг, дунд аж ахуйн нэгжид ХАБЭМ-ийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгардаг бэрхшээл, тэдгээрийг даван туулах аргуудын талаар санал бодлоо хуваалцахыг урих -Илтгэл 1 - Оролцогчдын хариултыг илтгэлтэй холбох	PPT илтгэл Суралцагчийн гарын авлагын Бүлэг 1

► Энэ танилцуулга хичээл тус бүр нь 30 минут үргэлжлэх 3 хэсгээс бүрдэнэ. Хичээлийн явцад оролцогчид жижиг, дунд аж ахуйн нэгжид ХАБЭМ-ийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгардаг бэрхшээл, ажлын байранд аюулгүй байдал, эрүүл мэндийг хэрхэн дэмжих талаар хэлэлцэж, мэдлэгтэй болно (СБ/Т 2).¹

Эхний илтгэлийн төгсгөлд оролцогчид жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд ХАБЭМ-ийн хүрээнд тулгардаг бэрхшээл, давуу тал, мөн түүнчлэн бусад асуудлын талаар ойлголттой болно. Нэг талаас аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны онцлог, хэмжээнээс хамаарсан хязгаарлагдмал тал, саад тотгор байдаг. Нөгөө талаас жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг бүхэлд нь авч үзвэл дэлхийн нийт хөдөлмөр эрхлэлтийн томоохон хэсгийг бүрдүүлж байна. Эдгээрт ажиллагчид ийнхүү дэлхийн хүн амын томоохон хэсгийг бүрдүүлж байгаа учир тэдний эрүүл мэнд, аюулгүй байдлыг сайжруулах нь дэлхий нийтийн эрүүл мэндэд шууд нөлөөлнө.

Энэ санааг тодотгохын тулд эрүүл мэндийг сайжруулж, бүтээмжийг дээшлүүлэх зорилготой ажлын байранд эрүүл амьдралын хэв маягийг дэмжих хөтөлбөрүүдийн (ажиллагчдын цайны газарт эрүүл хооллолтын цэс нэвтрүүлэх, ажиллагчдын дунд жин хасах, идэвхтэй хөдөлгөөний бүлгүүдийг дэмжих гэх мэт) жишээг ашиглаж болно. Ажилтнууд эдгээр зөв дадал зуршлаа цааш гэр бүл, найз нөхөддөө түгээх ач холбогдолтой. Иймд энэ хичээлээр ХАБЭМ-ийн арга хэмжээ бол зөвхөн хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн төдийгүй нийгэм, олон нийтийн илүү өргөн хүрээнд амьдралын чанарыг сайжруулахад нөлөөлнө гэсэн үзэл баримтлалыг танилцуулж, цаашид бусад бүх хичээлийн туршид өргөжүүлэн ярилцаж, бататгах юм.

ХИЧЭЭЛ 2. ХАБЭМ-ИЙН ТОДОРХОЙЛОЛТ БА ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД

Зорилго: Оролцогчид ХАБЭМ-ийн зорилго, зарчим, онцлог шинж, тус бүрийнх нь ач холбогдлыг тайлбарлаж чаддаг болно. Түүнчлэн тэд өөрийн оронд ашиглагдаж буй ХАБЭМ-ийн үндсэн ойлголтууд, үндэсний хууль тогтоомж, олон улсын туршлага зэргийн ижил төстэй болоод ялгаатай талыг мэдэж авна.² Мөн оролцогчид ажлын байранд аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх соёлыг нэвтрүүлж, төлөвшүүлэхийн ач холбогдлыг ойлгоно. Эцэст нь дэлхий нийтийн эрүүл мэндийг дэмжихэд ажлын байр чухал үүрэгтэйг онцолно.

¹ Нэг талаас энэ үйл ажиллагаа орхигдохоос сэргийлэх, нөгөө талаас таны хийх ажлыг хөнгөвчлөх зорилгоор уг дасгалыг холбогдох PPT илтгэлд оруулсан болно.

² Энэхүү удирдамжийн "Хэрэгтэй холбоосууд" хэсэгт үндэсний хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэм хэмжээний талаарх ОУХБ-ын мэдээллийн сангуудын холбоосыг орууллаа. Тухайн аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж буй орны хууль тогтоомжийн талаарх мэдээллийг үзэх боломжтой.

Арга хэлбэр: Лекц, аюулыг илрүүлэх, “аюул ба эрсдэл” сэдвээр бүлгийн хэлэлцүүлэг.

Материал: PPT илтгэл (хичээл 2), Дасгал: “Аюулыг олж илрүүлэх нь - Австралийн Нью Саут Уэльс мужийн ХАБЭМ-ийн агентлагийн жишээ (PPT илтгэл), Т/М 4

Хамрах агуулга: Суралцагчийн гарын авлагын Бүлэг 2.

Хугацаа: 2 цаг

Хичээлийн төлөвлөгөө			
Хугацаа	Агуулга	Арга	Хэрэглэгдэхүүн/ Тараах материал
90 мин	Хичээл 2: ХАБЭМ-ийн тодорхойлолт ба үндсэн ойлголтууд - Аюул - Эрсдэл - Хүлээн зөвшөөрөгдөх эрсдэл - Осолд дөхсөн тохиолдол - Аюултай тохиолдол - Үйлдвэрлэлийн осол - Мэргэжлээс шалтгаалсан өвчин - Хөдөлмөрийн аюулгүй байдал - Хөдөлмөрийн эрүүл мэнд - Урьдчилан сэргийлэлт - Аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх соёл	Оюуны довтолгоо: - “Аюул” гэдгийг юу гэж ойлгож байгааг оролцогчдоос асуух Лекц: - ХАБЭМ-ийн үндсэн ойлголтуудыг тодорхойлж, практик жишээгээр тайлбарлах - Оролцогчдод осолд дөхсөн тохиолдлыг мэдээлэх, бүртгэх, цаашид засаж залруулах арга хэмжээ авах зорилгоор судлахыг зөвлөх - Аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх соёл нэвтрүүлж, төлөвшүүлэхийн ач холбогдлыг онцлох	- PPT илтгэл - Суралцагчийн гарын авлагын Бүлэг 2.
30 мин	Дасгал: “Аюулыг олж илрүүлэх” - Австралийн Нью Саут Уэльс мужийн ХАБЭМ-ийн агентлагийн жишээ	Ганцаарчлан ажиллах: - Аюулыг илрүүлэх асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэх	- PPT илтгэл

Тэмдэглэл: Энэ хичээлээр ХАБЭМ-ийн талаар ерөнхий ойлголт өгч, сайжруулах арга хэмжээг төлөвлөх суурийг тавина. Үндсэн ойлголт, тодорхойлолтыг мэдэж авснаар оролцогчид цаашид “нэг хэлээр ярилцах” боломж бүрддэг. Хамгийн их төөрөгдөл үүсгэдэг аюул, эрсдэл гэх хоёр ойлголтын ялгааг тайлбарлах хэрэгцээ гарах байх.³ PPT илтгэлд энэ хоёр ойлголтын ялгааг тодорхой харуулсан зургийг оруулсан.

Хичээлээ цааш үргэлжлүүлэхийн өмнө оролцогчдоос энэ ялгааг тодорхой ойлгож авсан эсэхийг баталгаажуулж асуух хэрэгтэй. Тэднээс өөрсдийн мэдэж байгаа ажлын байрны аюул, эрсдэлийн жишээг хэлэхийг хүсээрэй. Дараа нь уг хоёр ойлголтын

³ “Аюул” гэж хүний эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй бүхий л зүйлийг хэлнэ. “Эрсдэл” бол аюулын улмаас хүн бэртэж гэмтэх, өвчлөх магадлал (их, бага) ба түүнээс учирч болох хохирлын ноцтой байдлыг харгалзан тооцдог үзүүлэлт юм.

ялгааг бусаддаа тайлбарлаж өгөхийг хүсээрэй. Энэ явцад тэдний ажигч, бүтээлч чадварыг нь онцолж, урамшуулах хэрэгтэй. Зарим аюул (хамгаалалтгүй ир, дүүжлээстэй ачаа, тээврийн хэрэгсэл гэх мэт) илэрхий, шууд харагдахуйц байдаг бол заримыг (эрс тэс температур, нян, химийн хорт бодис, сургалт дутмаг байдал, ажлын байрны хүчирхийлэл гэх мэт) нь илрүүлэхэд илүү хүчин чармайлт шаардлагатайг онцлоорой.

Энэ хичээлээр үйлдвэрлэлийн осол бус ажил, хөдөлмөртэй холбоотой өвчний улмаас илүү олон хүн амь насаа алддаг⁴ болохыг хэлж, оролцогчдыг гайхашруулах болов уу. Гэхдээ ажлын байрны эрүүл, аюулгүй байдлыг хангаснаар ийм осол, өвчлөлийн аль алинаас нь сэргийлж чадна гэдгийг тодорхой дурдах хэрэгтэй. Эрүүл мэнд хэмээх тодорхойлолтыг энэ сэдвийн хүрээнд ярилцах нь зүйтэй. Өмнө нь эрүүл мэндийг ямар нэгэн өвчин эмгэггүй байх хэмээн тодорхойлдог байсан бол өнөө үед сайн сайхан байдал⁵ хэмээх ойлголтыг багтаасан өргөн хүрээтэй ойлголт болсон билээ.

Цаашлаад нас, хүйс, эрүүл мэндийн байдал (жишээ нь, жирэмсэн, гэмтэж бэртээд, эсвэл өвчин тусаад эдгэрч байгаа, хөгжлийн бэрхшээлтэй болсон гэх мэт), шилжин суурьшилт болон бусад шалтгааны улмаас зарим ажилтан аюулд илүү өртөмхий, эрсдэлтэй байж болохыг ярилцах нь тун чухал. Оролцогчдоос тэдний ажлын байранд ийм эмзэг нөхцөлд буй ажилтан байгаа эсэх, тэдний хэрэгцээг хэрхэн шийдвэрлэж байгааг асууна. Үүгээр нөхцөл байдлыг сайжруулах зарим санаа гарч магадгүй. Орчин үеийн ХАБЭМ-ийн нэг гол тулгуур багана болсон урьдчилан сэргийлэх арга хэмжээний ач холбогдлыг тодотгохын тулд иймэрхүү агуулгатай зүйр цэцэн үг хэлэхийг хүсээрэй. Жишээ нь: “Бага залхуугаас их залхуу Бага хэргээс их хэрэг ” гэх мэт.

Зураг, зүйр цэцэн үгс ашиглах, хошин наргиа оруулах зэрэг нь оролцогчдын анхаарлыг татаж, төвлөрүүлэхэд тустай байдаг тул сургалтын туршид чөлөөтэй ашиглаарай.

ХИЧЭЭЛ 3. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮЙЛ ЯВЦ

Зорилго: Ажлын байранд ХАБЭМ-ийг сайжруулах гол хэрэгсэл болох эрсдэлийн үнэлгээг танилцуулна. Хичээлээр эрсдэлийн зураглал, матриц зэрэг эрсдэлийн үнэлгээний практик хэрэглэгдэхүүнүүдтэй танилцаж, хэрэглэж үзнэ.

Хичээлийн төгсгөлд оролцогчид эрсдэлийн үнэлгээний талаарх үндсэн ойлголтыг авахаас гадна дараах чадварыг эзэмшинэ:

- ▶ Аюулыг илрүүлэх
- ▶ Хэн, хэрхэн хохирч болохыг тодорхойлох
- ▶ Ажлын байран дахь эрсдэлийг үнэлэх
- ▶ Эрсдэлийн зураглал, матрицыг ойлгож, хэрэглэж сурах

⁴ Ойролцоогоор 6 дахин их

⁵ ДЭМБ “эрүүл мэнд” гэдгийг “хүн өвчин, эмгэггүй, бие бялдар, оюун санаа, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байх” хэмээн тодорхойлжээ.

Арга хэлбэр: Лекц, бүлгийн ажил, ганцаарчилсан ажил

Материал: PPT илтгэл (хичээл 3), Үйлдвэрийн дасгал 1 (PPT илтгэл), СБ/Т 4, Үйлдвэрийн дасгал 2. Тараах материал: Т/М 3 Эрсдэлийн үнэлгээний загвар; Т/М 5 Үйлдвэрийн дасгал 2: Эрсдэлтэй хүмүүсийг тодорхойлж, ажлын байрны эрсдэлийн түвшинг үнэлэх

Хамрах агуулга:

Суралцагчийн гарын авлагын Бүлэг 3

Хугацаа: 2 цаг 30 мин

Хугацаа	Агуулга	Арга	Хэрэглэгдэхүүн/ Тараах материал
60 мин	Хичээл 3: Эрсдэлийн үнэлгээ	Оюуны довтолгоо: Аж ахуйн нэгждээ аюулыг хэрхэн олж илрүүлдэгийг нь оролцогчдоос асуух Лекц Аюулыг илрүүлэхэд системтэй хандах үндэслэлийг тайлбарлах Эрсдэлийн үнэлгээний эхний алхмыг танилцуулах	PPT илтгэл Эргэдэг цаасан самбар Суралцагчийн гарын авлагын Бүлэг 3
20 мин	Үйлдвэрийн дасгал 1: Ажлын байрны аюулыг илрүүлэх. Оролцогч бүр өөрийн ажлын байран дахь гурван аюулыг бичнэ.	Ганцаарчилсан ажил	СБ/Т 3 Үйлдвэрийн дасгал 1
40 мин	Хичээл 3: Эрсдэлийн үнэлгээ: - Хэн, хэрхэн хохирч болох вэ? - Эрсдэлийг үнэлэх	Лекц Эрсдэлийн үнэлгээний 2 ба 3 дахь алхмыг танилцуулах	PPT илтгэл Суралцагчийн гарын авлагын Бүлэг 3
30 мин	Үйлдвэрийн дасгал 2: Ажлын байран дахь эрсдэлийг үнэлэх: Оролцогчид Үйлдвэрийн дасгал 1 дээр өгсөн хариулт, эрсдэлийн зураглал болон матрицыг ашиглаж, хэн, хэрхэн хохирч болохыг тодорхойлно.	Бүлгийн ажил	СБ/Т 4, Т/М 5 Үйлдвэрийн дасгал 2: Эрсдэлтэй хүмүүсийг тодорхойлж, ажлын байран дахь эрсдэлийн түвшинг үнэлэх Т/М 2

Тэмдэглэл:

1) Суралцагчийн гарын авлагад “Эрсдэлийн үнэлгээ хийх 5 алхам” гэсэн тараах материалын холбоосыг оруулсан болно. Уг материалд эрсдэлийг үнэлэх зөвлөмжөөс гадна аж ахуйн нэгжид эрсдэлийн үнэлгээ хийхэд чухал хэрэгцээтэй маягтын загвар (Т/М 3)-ыг оруулжээ.⁶

2) Эхний өдрийн төгсгөлд Т/М 2-т буй өдрийн үнэлгээний асуулгыг оролцогчдод тарааж өгч болно. Энэхүү тараах материалыг сургалтын багцтай хамтад нь, эсвэл эхний өдрийн сургалтын дараа тарааж болно. Сургалтын дараа өгөх нь сургалтын үед бусад зүйлд сатаарахаас сэргийлнэ. Уг үнэлгээний үр дүнгээс оролцогчид хүссэн зүйлээ сурч байгаа эсэхийг мэдэхийн зэрэгцээ хоёр дахь өдрийн хичээлийг боловсронгуй болгоход тус дөхөм болно.

► ХОЁР ДАХЬ ӨДӨР

ХИЧЭЭЛ 4. ЭРСДЭЛИЙГ ХЯНАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ШАТЛАЛ

Зорилго: Эрсдэлийг хянах арга болоод тэдгээрийн шатлалыг танилцуулна. Эрсдэлийг хянах талаар танай аж ахуйн нэгж одоо юу хийж байгааг дүгнэж шинжлэн, цаашид юу хийж болохыг танилцуулах зорилготой. Түүнчлэн эрсдэлийн хяналтын үндсэн хэсгүүд, аж ахуйн нэгжийн түвшинд эрсдэлийг хянахад чухал хувь нэмэр оруулдаг сайн туршлагын талаар ерөнхий ойлголт өгөх болно.

Хичээлийн төгсгөлд оролцогчид дараах чадварыг эзэмшсэн байна:

- Эрсдэлийг хянах арга хэмжээ гэж юу болох, хяналтын шатлалын дагуу тэдгээрийг хэрхэн сонгох, хэрэгжүүлэхийг мэдэх
- Эрсдэлийг хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл бууруулах хяналтын арга хэмжээг тодорхойлж, сонгох.

Арга хэлбэр: Лекц, бүлгийн ажил

Материал: РРТ илтгэл (хичээл 4), Т/М 3 “Эрсдэлийн үнэлгээний маягт”, Бэлэн хувцасны үйлдвэрийн дасгал ажилтай слайд. Видео: “Машин, тоног төхөөрөмжийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны бусад онцлог” (https://www.youtube.com/watch?time_continue=171&v=eXpNjATFSrU&feature=emb_title) үргэлжлэх хугацаа 2.51 мин

Хамрах агуулга: Суралцагчийн гарын авлагын Бүлэг 3

Хугацаа: 2 цаг

⁶ Дараах холбоосоор үзнэ үү: https://www.ilo.org/global/topics/safety-and-health-at-work/resources-library/publications/WCMS_232886/lang--en/index.htm

Хугацаа	Агуулга	Арга	Хэрэглэгдэхүүн/Тараах материал
90 мин	Хичээл 4: - Эрсдэлийг хянах арга хэмжээний шатлал - Материал, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, үйл явцыг сонгох - Засвар үйлчилгээ - Аюулгүй байдлын тэмдэг, тэмдэглэгээ - Ажил гүйцэтгэх журам, дүрэм Онцгой байдал, нүүлгэн шилжүүлэлтийн тогтолцоо Ажлын байрны эмх цэгц, зохион байгуулалт Ариун цэвэр, эрүүл ахуй Боловсрол, сургалт Дотоод хяналт	Оюуны довтолгоо: Аж ахуйн нэгждээ аюулыг хэрхэн олж илрүүлдэгийг нь оролцогчдоос асуух Лекц Аюулыг илрүүлэхэд системтэй хандах үндэслэлийг тайлбарлах Эрсдэлийн үнэлгээний эхний алхмыг танилцуулах Ганцаарчилсан ажил Лекц Эрсдэлийн үнэлгээний 2 ба 3 дахь алхмыг танилцуулах	РРТ илтгэл Суралцагчийн гарын авлагын Бүлэг 3 Видео: “Машин, тоног төхөөрөмжийн хамгаалалт, аюулгүй байдлын бусад онцлог”
30 мин	Бэлэн хувцасны үйлдвэрийн дасгал	Бүлгийн ажил	Бэлэн хувцасны үйлдвэрийн дасгалтай слайд

ХИЧЭЭЛ 5. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮЙЛ ЯВЦ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Зорилго: Урьдчилан сэргийлэх логик, үр дүнтэй стратеги болох хяналтын шатлалыг ашиглахын давуу талыг оролцогчдод ойлгуулна. Эрсдэлийн үнэлгээний 4 ба 5 дахь алхмыг танилцуулна. Үүнд эрсдэлийг хянах ямар арга хэмжээг хэн хариуцаж, хэзээ хэрэгжүүлэхийг тэмдэглэх ажил багтана. Мөн ажлын байран дахь эрсдэлийг хянахад хувь нэмэр оруулах бусад хүчин зүйлс, сайн туршлагын талаар нэмэлт мэдээллийг өгнө.

Хичээлийн төгсгөлд оролцогчид дараах чадварыг эзэмшсэн байна:

- ▶ Эрсдэлийг хянах арга хэмжээний талаарх мэдлэгээ гүнзгийрүүлнэ.
- ▶ Өмнөх дасгал ажлын үед тодорхойлсон эрсдэлийг бууруулахад ашиглаж болох хяналтын арга хэмжээг санал болгох.
- ▶ Эрсдэлийн үнэлгээний 4, 5 дахь алхмын талаар ойлгож авах.

Арга хэлбэр: Лекц, бүлгийн ажил

Материал: PPT илтгэл; Үйлдвэрийн дасгал 2-ын үр дүн; СБ/Т 5: Үйлдвэрийн дасгал 3

Хамрах агуулга: Суралцагчийн гарын авлагын Бүлэг 3

Хугацаа: 1 цаг 30 мин

Хугацаа	Агуулга	Арга	Хэрэглэгдэхүүн/ Тараах материал
50 мин	Хичээл 5: Эрсдэлийн үнэлгээний үйл явц (үргэлжлэл) Үйлдвэрийн дасгал 3: Өмнөх бүлгийн ажлын (үйлдвэрийн дасгал 2) үр дүнд үндэслэн эрсдэлийг хянах шатлалын дагуу тохирох, үр дүнтэй арга хэмжээг сонгох	Лекц Эрсдэлийг хянахад чухал ач холбогдолтой бусад хэсгийг тайлбарлах	PPT илтгэл Суралцагчийн гарын авлагын Бүлэг 3
40 мин		Бүлгийн ажил	Үйлдвэрийн дасгал 2-ын үр дүн; СБ/Т 5: Үйлдвэрийн дасгал 3

ХИЧЭЭЛ 6. ХАБЭМ-ИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Зорилго: ХАБЭМ-ийн удирдлагын тогтолцоог жижиг, дунд аж ахуйн нэгжийн хэрэгцээнд нийцүүлэх боломжтой, тэдгээрийн үйл ажиллагааных нь онцлогоос үүдсэн аюул, эрсдэлийг онцгойлон авч үздэг уян хатан тогтолцоо болохыг танилцуулна. Энэхүү хандлага нь тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой аюул, эрсдэлийг бүрэн үнэлж, урьдчилан сэргийлэх болон хяналтын үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх боломж олгодог гэдгийг харуулах. Мөн ХАБЭМ-ийг тасралтгүй сайжруулахад уг удирдлагын тогтолцоо чухал ач холбогдолтой бөгөөд үндэсний хууль тогтоомж, ОУХБ-ын эрхэм зорилго, удирдамжийн дагуу аж ахуйн нэгжийн түвшинд ажиллагчдын оролцоог дэмжих хэрэгслүүдийг санал болгодог болохыг онцлох.

Арга хэлбэр: Лекц, дүрд тоглох

Материал: PPT илтгэл (хичээл 6)

Хамрах агуулга: Суралцагчийн гарын авлагын Бүлэг 4

Хугацаа: 1 цаг

Хугацаа	Агуулга	Арга	Хэрэглэгдэхүүн/ Тараах материал
60 мин	Хичээл 6: ХАБЭМ-ийн удирдлагын тогтолцоо ХАБЭМ-ийн удирдлагын тогтолцооны тодорхойлолт, зорилго ХАБЭМ-ийн удирдлагын тогтолцоо болон аж ахуйн нэгж: - Аудит - Ажиллагчдын оролцоо, ХАБЭМ-ийн хороо байгуулах Аж ахуйн нэгжийн ХАБЭМ-ийн бодлого: - Зохион байгуулалт - Төлөвлөлт - Хэрэгжүүлэлт - Үнэлгээ - Сайжруулах арга хэмжээ	Лекц ХАБЭМ-ийн удирдлагын тогтолцоо нь ХАБЭМ-ийг тасралтгүй сайжруулах арга хэргсэл болохыг танилцуулах ОУХБ-ын эрхэм зорилгын дагуу ажиллагчдыг оролцуулахын ач холбогдлыг онцлох Аж ахуйн нэгжийн ХАБЭМ-ийн орчин цагийн бодлогын бүрэлдэхүүн хэсгүүд, бодлогыг хэрэгжүүлэх, хянаж үзэх, шинэчилж өөрчлөх алхмууд	РРТ илтгэл Суралцагчийн гарын авлагын Бүлэг 4

ХИЧЭЭЛ 7. АРГА ХЭМЖЭЭ АВАХ

Зорилго: Оролцогчдод аюулгүй байдлын үзлэг шалгалтын тайлан, осол, өвчний бүртгэл зэргээс хэрэгцээт мэдээллээ авах, гарч буй өөрчлөлтийг нүдээр болон шалгуур үзүүлэлт ашиглан хэмжих талаар танилцуулна.

Ингэснээр оролцогчид ХАБЭМ-ийг байнга сайжруулахын ач холбогдлыг ойлгох болно.

Оролцогчид сургалтын үеэр олж авсан ойлголт, арга барилдаа тулгуурлан өөрийн байгууллагынхаа эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлийг хянах арга хэмжээний бодитой саналыг боловсруулна. Дараа нь боловсруулсан саналаа бусадтайгаа ярилцах замаар харилцааны ур чадвараа ч мөн ахиулах юм. Төгсгөлд нь сургалтын үнэлгээний маягтыг бөглөж, хичээлийн агуулга, аргачлалыг үнэлэн, цаашид сайжруулах арга замыг санал болгоно.

Арга хэлбэр: Лекц, бүлгийн ажил, оролцогчдын илтгэл

Материал: РРТ илтгэл, Дасгал: Авах арга хэмжээний дасгал СБ/Т 6. Тараах материал: Т/М 6а, Үнэлгээний маягт 6б

Хамрах агуулга: Суралцагчийн гарын авлагын Бүлэг 4

Хугацаа: 1 цаг 30 мин

Хугацаа	Агуулга	Арга	Хэрэглэгдэхүүн/ Тараах материал
60 мин	Хичээл 7: Арга хэмжээ авах -Шалгуур үзүүлэлтүүд -ХАБЭМ-ийг тасралтгүй сайжруулах нь	Лекц Бүлгийн ажил: Дасгал: Арга хэмжээ төлөвлөх Хэлэлцүүлэг	РРТ илтгэл Суралцагчийн гарын авлагын Бүлэг 4
30 мин	Сургалтын үнэлгээ, санал зөвлөмж	Үнэлгээний маягтыг бөглүүлэх	Үнэлгээний маягт
Цагийн боломж гарвал энэ 20 минутын дасгал ажлыг хийлгэнэ.	Дасгал: ХАБЭМ-ийн хамтарсан хороо	Дүрд тоглох: Оролцогчид 2 бүлэгт хуваагдаж, менежерүүд болон ажилтны төлөөлөгчдийн дүрд тоглоно. Дараа нь дүрээ сольж тоглоно. Бүлэг тус бүр 2 хүн сонгож, жендэрт суурилсан хүчирхийллийн хэргийг ярилцах юм. Бүлгийн бусад гишүүд сонгосон төлөөлөгчиддөө зөвлөнө. Урьдчилан сэргийлэх, засаж залруулах арга хэмжээг санал болгоно.	СБ/Т 7

►

5. ТАРААХ МАТЕРИАЛ

►

Т/М 1: СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН МОДУЛЬ: АЖЛЫН БАЙРАА ЗОХИОН БАЙГУУЛАХ НЬ

Огноо:.....

Зохион байгуулагдах газар:.....

Цаг	Эхний өдөр	Хоёр дахь өдөр
90 мин	• Оролцогчдын танилцуулга • Сургалтын зорилго • Хөтөлбөрийн танилцуулга Хичээл 1: Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн ХАБЭМ-ийн нөхцөл байдал: тойм ба үндэслэл	Эхний өдрийн тойм ба хоёр дахь өдрийн танилцуулга Хичээл 4: Эрсдэлийг хянах арга хэмжээний шатлал
30 мин	Завсарлага	Завсарлага
30 мин	Хичээл 2: ХАБЭМ-ийн тодорхойлолт ба үндсэн ойлголтууд	Бэлэн хувцасны үйлдвэрийн дасгал
30 мин	Дасгал: Аюулыг олж илрүүлэх Дасгал: Австралийн Нью Саут Уэльс мужийн ХАБЭМ-ийн агентлаг (SafeWork NSW)-ийн жишээ	Хичээл 5: Эрсдэлийн үнэлгээний үйл явц (үргэлжлэл) Үйлдвэрийн дасгал 3: Хяналтын арга хэмжээ санал болгох Нэмэлт дасгал: Өрмийн машин
60 мин	Үдийн завсарлага	Үдийн завсарлага
60 мин	Хичээл 3: Эрсдэлийн үнэлгээ Алхам 1: Аюулыг илрүүлэх	Хичээл 6: ХАБЭМ-ийн удирдлагын тогтолцоо
30 мин	Завсарлага	Завсарлага
20 мин	Үйлдвэрийн дасгал 1: Ажлын байрны аюулыг илрүүлэх	Хичээл 7: Арга хэмжээ авах
40 мин	Алхам 2: Хэн, хэрхэн хохирч болохыг тодорхойлох. Одоо байгаа эрсдэлийг үнэлэх Алхам 3: Аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийг хянах арга хэмжээг тодорхойлж, сонгох	Авах арга хэмжээг төлөвлөх дасгал
30 мин	Үйлдвэрийн дасгал 2: Эрсдэлтэй хүмүүсийг тодорхойлж, ажлын байрны эрсдэлийн түвшинг үнэлэх	Сургалтын үнэлгээ ба санал зөвлөмж

► Т/М 2: ӨДРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН МОДУЛЬ: АЖЛЫН БАЙРАА ЗОХИОН БАЙГУУЛАХ НЬ

Огноо:.....

Модуль: ☐ Эхний өдөр ☐ Хоёр дахь өдөр

- Таалагдсан зүйлс:.....
.....
.....
.....
- Таалагдаагүй зүйлс:.....
.....
.....
.....
- Ойлгоогүй үлдсэн зүйлс:.....
.....
.....
.....
- Сайжруулах шаардлагатай зүйлс:.....
.....
.....
.....

► Т/М 3: ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ МАЯГТ

ОУХБ-ын Ажил олгогч, Ажилтан, тэдгээрийн төлөөллүүдэд зориулсан эрсдэлийн үнэлгээ хийх 5 алхамт зааварчилгаа. https://www.ilo.org/wcms-sp5/groups/public/---ed_protect/---protrav/---safework/documents/publication/wcms_232886.pdf 2013 оны 12 дугаар сарын 17

▲ Эрсдэлийн үнэлгээ:

Ажлын байрны үйл ажиллагаа: Эрсдэлийн үнэлгээ хийсэн огноо:

Ямар аюул байна вэ?	Хэн, хэрхэн хохирч болох вэ?	Одоо хяналтын ямар арга хэмжээ авч байгаа вэ?	Арилаагүй үлдсэн эрсдэл юу байна вэ?	Энэ эрсдэлийг хянахын тулд нэмж хийх зүйл байгаа юу?	Хариуцах эзэн	Гүйцэтгэсэн байх хугацаа	Гүйцэтгэсэн

Ямар аюул байна вэ?	Хэн, хэрхэн хохирч болох вэ?	Одоо хяналтын ямар арга хэмжээ авч байгаа вэ?	Арилаагүй үлдсэн эрсдэл юу байна вэ?	Энэ эрсдэлийг хянахын тулд нэмж хийх зүйл байгаа юу?	Хариуцах эзэн	Гүйцэтгэсэн байх хугацаа	Гүйцэтгэсэн

ОУХБ энэхүү загварыг Их Британийн ХАБЭМ-ийн албанаас нийтэлсэн мэдээлэлд үндэслэн боловсруулсан бөгөөд Их Британийн Засгийн газрын v1.0 лицензийн дагуу ашигласан болохыг мэдэгдэж байна.

► Т/М 4: АЖЛЫН БАЙРАНД БОЛСОН ТОХИОЛДЛЫГ МЭДЭЭЛЭХ МАЯГТЫН ЗАГВАР

► ЗААВАР

Ажлын байранд тохиосон бэртэл гэмтэл, өвчин, аюултай тохиолдол, осолд дөхсөн тохиолдлыг мэдээлэхэд энэ маягтыг бөглөнө. Бөглөсөн маягтыг-д хандан илгээнэ үү.

Энэ маягтыг дараах тохиолдлыг баримтжуулахад ашиглана:

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ	☐	АЮУЛТАЙ ТОХИОЛДОЛ	☐
МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧИН	☐	ОСОЛД ДӨХСӨН ТОХИОЛДОЛ	☐

► ӨРТСӨН ХҮН

Боломжтой бол гэмтсэн/оролцсон хүнээр бөглүүлнэ.

Маягт бөглөсөн хүний нэр:.....

Хүйс:..... Төрсөн огноо: Ажилд орсон огноо:.....

Албан тушаал:.....Нэгж:.....

Шууд удирдаж ажилладаг хүний нэр:.....

Тохиолдол болсон огноо, цаг:.....

Үйл явдал яг хаана тохиолдсон бэ?

Оролцсон/хамт байсан хүмүүс:

Тохиолдсон үйл явдлыг аль болох тодорхой бичнэ үү.

Жишээ нь:

- Холбогдох бодисын нэр;
- Холбогдох машин техник, тээврийн хэрэгслийн нэр, төрөл;
- Осолд хүргэсэн үйл явдлууд;
- Оролцсон хүмүүсийн гүйцэтгэсэн үүрэг.
- Хэрэв хүн гэмтсэн бол тухайн хүн юу хийж байсныг дэлгэрэнгүй бичнэ үү.
- Уг явдлаас хойш үүнтэй төстэй тохиолдол гарахаас сэргийлж авсан арга хэмжээг бичнэ үү.

Шаардлагатай бол тусдаа цаас хэрэглээрэй.

[illegible]

Гэрчүүд:.....

► ЗӨВХӨН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ЭСВЭЛ МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛД БӨГЛӨНӨ.

Гэмтэл/өвчний төрөл:.....

Ажлаас түр чөлөөлөгдсөн, бэртэж гэмтсэн болон анхны тусламж авсан шалтгаан:

Эмнэлгийн тусламж шаардагдсан уу? Тийм бол эмнэлэг/эмчийн нэр:



Тийм



Үгүй

Ажилтны гарын үсэг:.....

Огноо:.....

Шууд удирдаж ажилладаг хүний гарын үсэг:.....

Огноо:.....

► Т/М 5: ЭРСДЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙГ ТОДОРХОЙЛЖ, АЖЛЫН БАЙРАН ДАХЬ ЭРСДЭЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ

Тохиолдох магадлал	Учирч болох үр дагавар буюу хохирлын ноцтой байдал		
	Хохирол багатай	Хохирол дунд зэрэг	Хохирол ихтэй
Магадлал багатай	Бага эрсдэлтэй	Бага эрсдэлтэй	Дундаж эрсдэлтэй
Магадлалтай	Бага эрсдэлтэй	Дундаж эрсдэлтэй	Өндөр эрсдэлтэй
Өндөр магадлалтай	Дундаж эрсдэлтэй	Өндөр эрсдэлтэй	Өндөр эрсдэлтэй

УЧИРЧ БОЛОХ ҮР ДАГАВАР БУЮУ ХОХИРЛЫН НОЦТОЙ БАЙДАЛ

Хохирол багатай: Үүнд анхны тусламж, бага зэргийн эмчилгээ үзүүлэх шаардлагатай гэмтэл, өвчлөлийг хамруулж ойлгоно. Энэ тохиолдолд тухайн хүн ажлаасаа чөлөөлөгдөх шаардлага гарвал нэг, хоёр өдрөөс хэтрэхгүй.

Хохирол дунд зэрэг: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаанд алдахад хүргэхээр бүрэн эдгэх боломжтой арай хүнд гэмтэл, өвчлөл (Жишээ нь: гар хугарах, яс бага зэрэг цуурах). Энэхүү гэмтэл, өвчлөлийн улмаас тухайн хүн нэлээд удаан хугацаанд ажиллах боломжгүй болдог.

Хохирол ихтэй: Амь насаа алдах, маш хүнд гэмтэх, өвчлөх. Гэмтэл, өвчлөл нь урт хугацааны, эсвэл насан туршид үргэлжлэх үр дагавартай (хиймэл эрхтэн хийлгэх, дуу шуугианаас болж сонсголоо алдах гэх мэт). Ийм нөхцөлд “амьдралын хэв маягийг огцом өөрчлөхүйц хэмжээний бэртэл гэмтэл” гэсэн нэр томьёо хэрэглэдэг.

ҮЙЛ ЯВДАЛ БОЛОХ МАГАДЛАЛ

Магадлал багатай: одоо байгаа нөхцөлд хэн нэгэн гэмтэх магадлал маш бага.

Магадлалтай: одоо байгаа нөхцөлд хэн нэгэн гэмтэх, өвчлөх магадлалтай.

Өндөр магадлалтай: одоо байгаа нөхцөлд хэн нэгэн өвчлөх, гэмтэх нь тодорхой.

► Т/М 6А: САЙЖРУУЛАХ САНАЛ

► Эрсдэлийн үнэлгээ

1	
2	
3	
4	
5	

► Ажлын байранд ХАБЭМ-ийн удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх

1	
2	
3	
4	
5	

- Яаралтай арга хэмжээ шаардсан, өндөр эрсдэлтэй зүйлсийг тодорхойлох.
- Хялбар хэрэгжүүлж болох үр дүнтэй арга хэмжээг дараах асуултуудыг асуух замаар тодорхойлно:
 - Сайжрах магадлал хэр байгаа вэ?
 - Одоо шууд хэрэгжүүлж эхлэх боломжтой юу?
 - Их хэмжээний хөрөнгө оруулалтгүйгээр хэрэгжүүлэх боломжтой юу?
 - Сарын дотор эхний үр дүн гарах боломжтой юу?
- Санаа бүрийг дээрх асуултын дагуу 0, 1, 2 од (*)-оор урамшуулна.
- 6-10 сайжруулах санааг сонгоно.
- Багаараа эдгээр санааг ярилцаж, тохирно.
- Од нь “богино хугацаанд үр дүн гарах” арга хэмжээг илтгэнэ.

► Т/М 6Б: АЖ АХУЙН НЭГЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Төсөл ба дэд үйл ажиллагаа	Хариуцах хүн	Шалгуур үзүүлэлт	Эзлэх хугацаа	Дуусгах хугацаа (төлөвлөгөө)	Дуусгах хугацаа (гүйцэтгэл)	Тайлбар
1	1.1						
	1.2						
	1.3						
	1.4						
2	2.1						
	2.2						
	2.3						
	2.4						
3	3.1						
	3.2						
	3.3						
	3.4						
4	4.1						
	4.2						
	4.3						
	4.4						
5	5.1						
	5.2						
	5.3						
	5.4						

► Т/М 7: СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ

Та сургалтын талаарх бодлоо хуваалцана уу. Хариулах боломжгүй асуулт байвал хоосон орхино уу. Асуулт бүрд харгалзах тоог дугуйлж үнэлээрэй.

		Санал бүрэн нийлж байна	Санал нийлж байна	Санал нийлэх, нийлэхгүйн аль нь ч биш	Санал нийлэхгүй	Огт санал нийлэхгүй
1	Агуулга нь сэдвийг бүрэн хамарсан.	5	4	3	2	1
2	Агуулга нь миний мэдлэг туршлагад тохирсон.	5	4	3	2	1
3	Сургалтын агуулгын нягтрал тохирсон (хэт шахуу биш).	5	4	3	2	1
4	Тараах материал, хэрэглэгдэхүүн нь тохиромжтой.	5	4	3	2	1
5	Оролцогчдын идэвхтэй оролцоог дэмжиж байсан.	5	4	3	2	1
6	Дасгал ажлууд нь агуулгаа ойлгоход тусалсан.	5	4	3	2	1
7	Сургагч багш агуулгаа ойлгоход тусалсан.	5	4	3	2	1
8	Сургагч багш асуултад бүрэн дүүрэн хариулт өгч байсан.	5	4	3	2	1
9	Сургалтын ерөнхий зохион байгуулалт, цаг хуваарилалт сайн байсан.	5	4	3	2	1
10	Сургалт зохион байгуулсан газар, хэрэглээний зүйлс нь миний хэрэгцээнд тохирсон.	5	4	3	2	1

11. Сургалтын үргэлжлэх хугацаа нь:

Яг тохирсон уу? ☐ Хэт богино байв уу? ☐ Хэт урт байв уу? ☐

12. Сургалтын өмнө та энэ сэдвийг хэр сонирхож байсан бэ?

Маш их ☐ Их ☐ Дунд зэрэг ☐ Бага ☐ Маш бага ☐

13. Сургалтын дараа таны сонирхол ямар түвшинд хүрсэн бэ?

Маш их ☐ Их ☐ Дунд ☐ Бага ☐ Маш бага ☐

СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХЭСЭГ

14. Цаашид сургалтыг сайжруулах талаар санал, зөвлөмж байна уу?

15. Та сургалтыг ерөнхийд нь хэрхэн үнэлэх вэ?

Маш сайн ☐

Сайн ☐

Дунд ☐

Муу ☐

Маш муу ☐

16. Сургалтын талаар өөр санал, хүсэлт байна уу?

►

6. СУРГАГЧ БАГШИД ЗОРИУЛСАН ТЭМДЭГЛЭЛ

►

СБ/Т 1: СУРГАГЧ БАГШИЙН ХИЙХ АЖИЛ

Дараах жагсаалтыг ашиглан сургалтаа төлөвлөж бэлтгээрэй. Шаардлагатай зүйлсээ нэмж оруулна уу.

Хийх зүйлс	Гүйцэтгэж дуусах хугацаа	Төлөв
Шаардлагатай бол ОУХБ-ын багтай уулзаж, сургалтын модуль, оруулах өөрчлөлтийг ярилцах. Сургалтад оролцогч аж ахуйн нэгжүүдийн мэдээлэлтэй танилцах.		
Сургалтын сэдэвт хамаарах хууль тогтоомжийн талаарх мэдээллийг цуглуулах		
Хичээлийн төлөвлөгөө, гол агуулга, үйл ажиллагааг хянан үзэж, шаардлагатай бол нэмэлт оруулах		
Сургалтын бүх материалыг бэлтгэж, тараах материалыг хувилж олшруулах		
Шаардлагатай нэмэлт хэрэглэгдэхүүн, материалыг бэлтгэх		
Сургалтыг удирдан явуулах		
Сургалт, үнэлгээний үр дүнг хянаж дүгнэх		
SCORE багийнхантай уулзаж, аж ахуйн нэгжид очиж ажиллах хуваарийг эцэслэх		

►

СБ/Т 2: ДАСГАЛ: ЖИЖИГ БИЗНЕС, ТОМ СОРИЛТ

Хугацаа: 10 мин.

Аргачлал: Ганцаарчлан ажиллана. Ажлын байр, нийгэм, байгаль орчинд ХАБЭМ ямар ач холбогдолтойг ойлгуулах зорилготой.

Ажлын байр нь нийгмийн эрүүл мэнд болон дэлхий нийтийн эрүүл мэндийг дэмжихэд ямар хувь нэмэр оруулж болохыг бичихийг оролцогчдоос хүсээрэй.

Зөвлөмж: Оролцогчид жижиг, дунд аж ахуйн нэгжүүд дэлхий дахины эрүүл мэндийн нөхцөл байдалд хэрхэн нөлөөлж болохыг бодож үзэх хэрэгтэй. Өнөөгийн цар тахлын нөхцөлд тэдний гүйцэтгэж буй үүрэг тодорхой жишээ болно. Энд “зөв”, “буруу” гэсэн хариулт байхгүй. Харин санаагаа тодорхой үндэслэл, бодит баримт мэдээлэлтэй гаргах нь зүйтэй.

ХАБЭМ-ийн ач холбогдлыг дан ганц ажлын байраар хязгаарлалгүй илүү өргөн хүрээнд ойлгож, хүлээн зөвшөөрөх нь нийт нийгмийн хувьд ашиг тустай сайн туршлагыг дэмжих арга зам болно.

► СБ/Т 3: ҮЙЛДВЭРИЙН ДАСГАЛ 1. АЖЛЫН БАЙРАН ДАХЬ АЮУЛЫГ ИЛРҮҮЛЭХ

Хугацаа: 20 мин.

Аргачлал: Ганцаарчлан ажиллана. Оролцогчдоос өөрийн ажлын байран дээр ажигласан гурван аюулыг бичихийг хүснэ.

Уг дасгалын үеэр оролцогчид хоорондоо ярихгүй байхыг сануулна. Энэхүү дасгал нь оролцогч бүр бусдын нөлөөгүйгээр бие дааж аюулыг тодорхойлоход оршино. Хэрэв ярилцахыг зөвшөөрвөл зарим (манлайлагч, нээлттэй) хүний санал дуугай/бүрэг нэгнийхээ санал бодлыг дарж, бүтээлч сэтгэлгээг сааруулж болзошгүй. Аюул ямар ч байж болохыг тэдэнд сануулахын зэрэгцээ та өөрөө зарим жишээ хуваалцах хэрэгтэй. Тухайлбал, маш идэмхий хүчил, дуу чимээ, вирус, стресс, биед эвгүй байрлал гэх мэт.

Оролцогчдоос бичсэн жагсаалтаа танилцуулахыг хүс. Энд гол нь “эрсдэл” биш “аюул”-ыг тодорхойлсон байхад анхаарах юм. Учир нь оролцогчид уг жагсаалтаа сургалтын явцад ашиглах болно. Хүсвэл эрсдэлийн үнэлгээний маягыг хувилж бөглүүлэх боломжтой.

► СБ/Т 4: ҮЙЛДВЭРИЙН ДАСГАЛ 2: АЖЛЫН БАЙРАН ДАХЬ ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ

Үйлдвэрийн дасгал 1-д гаргасан жагсаалт, эрсдэлийн зураглал, матрицаа ашиглан өөрийн байгууллага дахь эрсдэлийн үнэлгээг нэг шат ахиулж хэн, хэрхэн хохирч болохыг тодорхойлно.

Хугацаа: 30 мин.

Аргачлал: Бүлгийн ажил.

Оролцогчдыг жижиг бүлгүүдэд хуваана. Ажлын байраа мэддэг байх нь эрсдэлийн зураглал хийж, үнэлэхэд чухал тул нэг аж ахуйн нэгжийн 6-5 хүн нэг бүлэгт байхаар зохион байгуулах нь зүйтэй. Өмнө ганцаарчлан ажилласан дасгал (Үйлдвэрийн дасгал 1)-ын үр дүнд үндэслэн аж ахуйн нэгжийнхээ (нэг, эсвэл хэд хэдэн нэгжийг сонгож болно) бүдүүвч зургийг гаргаж, эрсдэлтэй гэж үзэж байгаа газрыг (эрсдэлийг

дугуй, эсвэл бусад энгийн дүрсээр тэмдэглэж, мөн хүсвэл өнгөөр ялгаж болно) тэмдэглэнэ. Түүнчлэн хаалга, цонх, явган шат, гарц, машин, тоног төхөөрөмж гэх зэрэг гол зүйлсийг дүрсэлнэ. Гол ажилтнуудын (жишээлбэл, галын бригад, аюулгүй байдал хариуцсан төлөөлөгчид, анхны тусламжийн ажилтан) байршлыг эрсдэлийн зураг дээр мөн зааж өгөх ёстой.

Эрсдэлийн зураглал нь тухайн аж ахуйн нэгжийн ХАБЭМ-ийн өнөөгийн нөхцөл байдал (эрсдэл хаана байрлаж байгааг)-ыг схемчилсэн байдлаар илэрхийлсэн дүрслэл тул зургийн нарийн ур чадвар шаардлагагүй гэдгийг оролцогчдод анхааруулаарай. Энэхүү бүлгийн ажил нь хүн бүрийн олж анзаарсан эрсдэлийг тусгасан цогц зураглал гаргахын зэрэгцээ багийн хамтач сэтгэлгээг дэмждэг.

Эрсдэлийн зураглал бэлэн болмогц бүлэг бүр суралцагчийн гарын авлагад буй эрсдэлийн энгийн матриц ашиглан тэмдэглэсэн эрсдэл бүрээ үнэлнэ. Энэ алхам нь эрсдэл бүрийг тохиолдох магадлал (боломж) ба үр дагаврын⁷ нь ноцтой байдалд үндэслэн эрэмбэлэхэд тусална. Өөрөөр хэлбэл эрсдэлийн матриц нь аль эрсдэлийг нэн түрүүнд шийдвэрлэх шаардлагатайг (эрсдэлийн матрицын улаан, шар бүс буюу дундаж, өндөр эрсдэлтэй) тодорхойлоход тусална.

Эрсдэлийг тодорхойлж, үнэлэн эрэмбэлсний дараа (Эрсдэлийн үнэлгээний Алхам 2: Хэн, хэрхэн хохирч болох вэ?) эрсдэлийг хянах арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх шатанд шилжинэ (Үйлдвэрийн дасгал 3-ыг үзнэ үү). Эрсдэлийн зураглал болон үнэлгээний үр дүнг бичиж тэмдэглэн хадгалах, хэрэг гарсан үед хэрэглэхэд бэлэн байлгах шаардлагатайг оролцогчдод сануулаарай. Жишээ нь, аж ахуйн нэгжид шинэ тоног төхөөрөмж суурилуулах, ажлын байрны зохион байгуулалт өөрчлөгдөх зэрэг тохиолдолд уг зураглал, үнэлгээнд зохих өөрчлөлт оруулах шаардлагатай болно. Мөн ажлын байрны үзлэг шалгалт, аудит хийгдэх үед үзэх хэрэгтэй болдог. Сургагч багшийн хувьд та эрсдэлийн матриц ашиглахын сул талыг (тухайлбал, магадлал, ноцтой байдлыг тооцоход субъектив байдлаар хандаж болзошгүй) мэддэг байх хэрэгтэй.

Гэхдээ энэ нь мэргэжлийн бус хүн ч хэрэглэхэд хялбар, үр дүнтэй арга гэдгийг онцлоорой. Дасгалыг дуусгахдаа оролцогчдод эрсдэлийн үнэлгээний энэхүү арга барилыг бүтээлчээр ашиглан, аж ахуйн нэгжийнхээ хэрэгцээ, нөөцөд⁸ тохируулан ямар ч үйл ажиллагаа, аргыг сайжруулж болохыг сануулах нь зүйтэй.

Оролцогчид эрсдэлийн одоогийн түвшинг тодорхойлох дасгалын үед «Эрсдэлийн түвшинг матрицаар үнэлэх» илтгэлийн хэсгийг дэлгэцэн дээр харуулахыг зөвлөж байна. Мөн энэхүү удирдамжид буй Т/М 5-ын “Магадлал ба ноцтой байдлын тодорхойлолт”-ыг ашиглах боломжтой.

Оролцогчдод хариултаа бичиж авахыг сануулна. Сургагч багш нар оролцогчдын гүйцэтгэлийг ажиглан, бүлэг бүр Үйлдвэрийн дасгал 3-т ашиглах дор хаяж нэг дундаж/өндөр түвшний эрсдэл тодорхойлсон байхад анхаарна.

7 Эрсдэлийн магадлал ба ноцтой байдлын ангилал бүрийг Суралцагчийн гарын авлагын Бүлэг -3ын “Эрсдэлийн матриц” гэсэн хэсэгт нарийн тодорхойлсон болно.

8 Сүүлийн үед хэрэглээ нь нэмэгдэж буй гар утасны апп-ууд эрсдэлийн үнэлгээнд чухал хувь нэмэр оруулж болох юм. ОУХБ-ын зарим хэрэгцээт апп-уудын мэдээлэл авах холбоос: <https://www.ilo.org/global/publications/apps/lang--en/index.htm>

СБ/Т 5. ҮЙЛДВЭРИЙН ДАСГАЛ 3: ҮЙЛДВЭРИЙН ДАСГАЛ 2-Т ҮНЭЛСЭН ЭРСДЭЛИЙГ ХЯНАЛТЫН ШАТЛАЛЫН ДАГУУ ХЯНАХ АРГА ХЭМЖЭЭГ САНАЛ БОЛГОХ

Үйлдвэрийн дасгал 2-ын үр дүнд тулгуурлан хяналтын шатлалын дагуу эрсдэлийг хянах хэрэгжих боломжтой, тохирох арга хэмжээг сонгоно.

Хугацаа: 15 мин.

Аргачлал: Бүлгийн ажил. Өмнөх дасгалыг гүйцэтгэсэн бүрэлдэхүүнээрээ дахин бүлгээр ажиллахыг хүснэ. Ингээд аж ахуйн нэгжийнхээ түвшинд олж илрүүлж, байршлыг нь тогтоон эрэмбэлсэн эрсдэлийг хянах бодитой арга хэмжээнүүдийг санал болгохыг даалгана. (Одоо бид Суралцагчийн гарын авлагад заасан эрсдэлийн үнэлгээний 3 дахь алхамын “Одоо ямар арга хэмжээ авч байгаа вэ? Цаашид эрсдэлийг бууруулахын тулд ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?” гэсэн асуултуудад хариулах болно). Авах арга хэмжээг төлөвлөхдөө хяналтын шатлалыг харгалзан үзэхийг оролцогчдод сануулаарай. Дасгалыг гүйцэтгэх явцад “Эрсдэлийг хянах арга хэмжээний шатлал”-ыг харуулсан хуудсыг дэлгэцэн дээр гаргаж болно. Аюулыг юуны түрүүнд арилгах ёстойг чухалчлах ёстой. Хэрэв арилгах боломжгүй бол аюулгүй хувилбараар солих хувилбаруудыг авч үзэх шаардлагатай. Эрсдэлийг хянах логик дарааллын учир зүйг онцлох үүднээс хяналтын энэхүү хоёр арга хэмжээ хамгийн үр дүнтэй гэдгийг хэлнэ. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлсний дараа “үлдэгдэл эрсдэл” байвал нийт хүмүүсийг бүхэлд нь хамрах хамтын хамгааллын арга хэмжээг авч үзнэ. Харин хувь хүнд чиглэсэн хамгааллын арга (жишээ нь, хувийн хамгаалах хэрэгсэл) хамгийн сүүлчийн сонголт байх ёстой. Жижиг, дунд аж ахуйн нэгжүүд ихэвчлэн хувийн хамгаалах хэрэгслийг хяналтын гол арга болгох хандлагатай байдаг тул энэ дасгал нь “хяналтын шатлалын” логик дарааллыг ойлгуулж, нийтлэг байдаг буруу ойлголтыг засах ач холбогдолтой.

Оролцогчид эрсдэлийн үнэлгээнийхээ үр дүнг “Эрсдэлийн үнэлгээний маягт”-ыг (Т/М 3) ашиглан бичиж болно.

► СБ/Т 6. ДАСГАЛ: АРГА ХЭМЖЭЭ АВАХ

Хугацаа: Дасгалыг 1 цаг гүйцэтгэнэ. Дараа нь аж ахуйн нэгжийг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэлэлцэхэд 20 минут зарцуулна.

Аргачлал: Бүлгийн ажил

Оролцогчид өмнөх хичээлүүдээр аж ахуйн нэгжийнхээ эрсдэлийн үнэлгээг хийж, хяналтын хэрэгжих боломжтой⁹, тохирох арга хэмжээг боловсруулахад шаардлагатай ойлголт, зарчим, аргуудыг сурч мэдсэн билээ. Тэгвэл энэхүү сүүлчийн дасгалаар эдгээрийг ашиглаж бататгах боломж гарна. Дасгалын зорилго нь (i) сургалтын туршид сурсан зүйлс, өмнөх бүх дасгалын үр дүнг нэгтгэн дүгнэх; (ii) оролцогчдод өөрсдийн байгууллагад эрсдэлийн үнэлгээг хийхдээ аль хэсгийг түрүүлж үнэлэх,

9 Санал болгож буй хяналтын арга хэмжээ нь тухайн байгууллагын бодит боломжийг харгалзан үзсэн байх шаардлагатай.

ямар үндэслэлээр сонгох талаар бодох боломж олгох (осол их гардаг хэсэг, ХАБЭМ-ийн мэргэжилтэн идэвхтэй ажилладаг газар гэх мэт); (iii) “Үйлдвэрлэлийн талбайн аюулгүй байдал, эрүүл мэндийн үзүүлэлтээр танай ажлын байр хэр зэрэг түвшинд байгаа вэ?” гэсэн слайд дээр үзүүлсэн “зүү” аль ажлын байранд хөдөлгөхөөр байна вэ? Тухайлбал, удирдлагын хүсэл эрмэлзэл, үүрэг хариуцлагыг тодорхой тогтоох, хяналтын механизм бий болгох, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох гэх мэт.

Оролцогчид үйлдвэрийн дасгалаа гүйцээж, эрсдэлийн үнэлгээний 4 дэх алхам буюу эрсдэлийг хянах арга хэмжээг хариуцах хүн, бодит хугацааг тодорхойлон маягтад бөглөнө. “Сайжруулах саналын жагсаалт”-д оролцогчид аж ахуйн нэгжийнхээ ямар хэсэгт, ямар учраас эрсдэлийн үнэлгээ эхэлж хийх вэ гэдгээ тодорхойлж бичнэ. Тэгээд дараа нь ажлын байрандаа ХАБЭМ-ийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, нэгэнт нэвтэрсэн газарт сайжруулах, гүйцэтгэлийг нь хянахын тулд ямар арга хэмжээ шаардлагатайг төлөвлөх ёстой.

Сургалт хугацаандаа багтахын тулд энэхүү дасгалын хугацааг нэг цагаас хэтрүүлэх хэрэггүй. Гэхдээ оролцогчид сургалтын дараа ажлын байран дээрээ очоод аж ахуйн нэгжийнхээ онцлог хэрэгцээнд нийцсэн шалгах хуудас, боловсруулж ашиглах боломжтой гэдгийг сануулаарай. Бүлэг бүр эрсдэлийн үнэлгээнийхээ үр дүнг “Аж ахуйн нэгжийг сайжруулах төлөвлөгөө”-ний маягтад (Т/М 6б) бичихийг даалгана. Ингэснээр дараа нь хэлэлцүүлгийн үед бүлгийн ажлын үр дүнг илтгэхэд хэрэг болно.

Сургагч багшийн хувьд та бүлэг бүрд туслахад бэлэн байж, асуулт гарвал хариулна. Гэхдээ бүлгүүд ажлын байрны талаарх өөрсдийн мэдлэг, ажлын туршлага, оюун ухаанаа ашиглан бие дааж ажиллах боломжийг олгоно. Сургалтын туршид олж авсан мэдлэг нь оролцогчдын итгэлийг бэхжүүлж, энэ шатанд сайжруулах санаанууд аяндаа л урсан гарах болно. Таны үүрэг бол оролцогчдын бүтээлч сэтгэлгээг дэмжих, мөн дасгалын төгсгөлд хийгдэх хэлэлцүүлэгт шүүмжит сэтгэлгээг өдөөх явдал юм. Жишээ нь, та бүлэг бүрээс яагаад зүгээр л чихний хамгаалалт (чихний бөглөөс, чихэвч) тараагаад өгөхийн оронд дуу чимээг багасгах инженерийн хяналтын арга хэмжээ (хэвлэх машины тусгаарлалт, хамгаалалт) санал болгосныг асууж болно. Өөрөөр хэлбэл, хэлэлцүүлгийн үед та «эсрэг талын өмгөөлөгч»-ийн дүрд орж, санал болгож буй арга хэмжээг хамгаалсан логик үндэслэл гаргахад тусална.

Шинээр нэвтрүүлэх хяналтын аль ч арга хэмжээ (техникийн, эсвэл зохион байгуулалтын шинжтэй, хамт олонд, эсвэл хувь хүнд чиглэсэн гэх мэт) ихэнх тохиолдолд зардал шаарддаг. Иймд ажилтнуудын төлөөлөл, удирдлага, ажил олгогч нарт санал болгож байгаа шийдлийнхээ үр дүн, тохиромжтой байдлыг ойлгуулж итгүүлэх чадвартай байх ёстой. Жишээлбэл, боломжтой тохиолдолд ХАБЭМ-ийн үндэсний болон олон улсын найдвартай эх сурвалжаас (бусад байгууллага, холбоод, хэвлэл, аж ахуйн нэгж, үйлдвэрчний эвлэл гэх мэт) авсан статистикийн мэдээллийг ашиглаж болох юм.

Хувь хүний болоод хэсэг бүлгийн хувийн үзэл бодлоос хамааралгүй объектив шинжтэй ийм тоон мэдээлэл нь таны саналд бодитой үндэслэл болж өгнө. Хэлэлцүүлгийн үе шатыг аж ахуйн нэгжийг сайжруулах арга хэмжээнд чиглүүлж, тодорхой, энгийн явуулахыг хичээгээрэй. Бүлэг бүрийн хамгийн чухал саналуудыг цаасан самбар дээр бичиж, бүх хүнд харагдахуйц байрлуулна (утсаараа зургийг нь авч оролцогчдод цахим шуудангаар илгээж болно). Түүнчлэн сургагч багш үр дүнг эерэгээр үнэлж, оролцогчдыг урамшуулах хэрэгтэй. “Та нар аж ахуйн нэгжийн өдөр

тутмын ажлыг илүү таатай болгож сайжруулах аргуудыг сонгосон нь их таатай санагдаж байна. Амрах бүсэд тохилог суудал, ширээ, ундны хүйтэн ус байрлуулах нь энгийн, хямд боловч ажилтнуудад ялангуяа халуун улиралд их хэрэгтэй зохион байгуулалт болохоор байна. Бусад бүлгээс нэмэлт санал байна уу?” гэх мэтээр чиглүүлж болно. Бүлэг бүрээс нэмэлт санал гаргахыг дэмжинэ. Жишээ нь: “Амрах бүсийн ширээн дээр ХАБЭМ-ийн сэдэвтэй тараах материал, хэрэгсэл зэргийг байрлуулбал ажилтнууд уншиж танилцан, цааш хамт ажиллагчид, гэр бүлийнхэндээ түгээх боломжтой”.

► СБ/Т 7. ДАСГАЛ (СОНГОЛТООР): ХАБЭМ-ИЙН ХАМТАРСАН ХОРОО

Хугацаа: 20 мин.

Аргачлал: Дүрд тоглох дасгал. Оролцогчдыг ажилтнууд ба менежерүүдийн дүрд тоглуулахаар хоёр бүлэг болгон хуваана. Эхний тоглолтын дараа тэд дүрээ солино. Дараа нь бүлэг тус бүр хоёр төлөөлөгч сонгож, жендэрт суурилсан хүчирхийллийн тохиолдлыг хэлэлцэнэ. Бүлгийн бусад гишүүн өөр өөрийн төлөөлөгчдөд зөвлөгөө өгч, дэмжих ёстойг хэлнэ.

Энэ дасгалын зорилго нь ажлын байранд тохиолддог жендэрийн нийтлэг асуудалд анхаарлаа хандуулах, харилцан хүндэтгэл, оролцоог дэмжих, эрүүл, аюулгүй ажлын орчин хэзээд хүчирхийлэл, дарамтаас ангид байх ёстойг онцлох, мөн аж ахуйн нэгжийн ХАБЭМ-ийн хамтарсан хороо аливаа дарамтаас сэргийлэх, нөхцөл байдлыг засаж залруулах практик арга хэмжээг санал болгох жишээг үзүүлэхэд оршино. Энэ дасгалыг дуусгахдаа аж ахуйн нэгжийн түвшинд хүчирхийлэл, дарамтын бүх хэлбэрийг хүлээн зөвшөөрөхгүй байх нь хүн бүрийн хариуцлага гэдгийг дахин онцолно.

ХЭРЭГЦЭЭТ ХОЛБООС

ХАБЭМ - Хөдөлмөрийн байцаагч болон бусад оролцогч талын гарын авлага
<https://www.ilo.org/global/topics/labour-administration-inspection/resources-library/publications/guide-for-labour-inspectors/lang-en/index.htm>

ЖДҮ-ийн ажлын байрны эрсдэлийн үнэлгээ, менежментийн сургалтын гарын авлага
https://www.ilo.org/global/topics/safety-and-health-at-work/resources-library/training/WCMS_215344/lang-en/index.htm

Ажил олгогч, ажилтан болон тэдний төлөөлөлд зориулсан ажлын байрны эрсдэлийн үнэлгээ явуулах 5 алхамын заавар https://www.ilo.org/global/topics/safety-and-health-at-work/resources-library/publications/WCMS_232886/lang-en/index.htm

ХАБЭМ-ийн ОУХБ-ын энциклопед (2012): <https://www.iloencyclopaedia.org/>

ДЭМБ. Эрүүл мэндийн сэдэв: Хөдөлмөрийн эрүүл мэнд: <https://www.who.int/health-topics/occupational-health>

ОУХБ. ХХХ таныг эрүүл, аюулгүй байхад тусална. https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_dialogue/---lab_admin/documents/instructionalmaterial/wcms_537874.pdf
2016 оны 12 дугаар сарын 13.

Галын аюулгүй байдлын арга хэмжээний хяналтын хуудас https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_protect/---protrav/---safework/documents/publication/wcms_194782.pdf

Жижиг үйлдвэрийн сайжруулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх (WISE) дэлхийн гарын авлага - WISE үйлдлийн хяналтын хуудас 8 https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_protect/---protrav/---safework/documents/instructionalmaterial/wcms_621054.pdf

ОУХБ-ын донор байгууллагууд



Олон улсын хөдөлмөрийн байгууллага
НҮБ-ын байр, 604 тоот
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар -14201, Монгол Улс



+976- 11320624



ulaanbaatar@ilo.org



ilo.org/mongolia



Олон улсын хөдөлмөрийн байгууллага- International
Labour Organization



[@ilo_mongolia](https://twitter.com/ilo_mongolia)